**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

**2024** оны 12 сарын 02 Дугаар 9СА-31/2024 Сайншанд сум

## НЭГ.УДИРТГАЛ ХЭСЭГ

Монгол Улсын Дорноговь аймаг, Замын-Үүд суманд байршилтай **Хилийн Замын-Үүд боомт, ачаа тээврийн цогцолборын шатамхай бодисын агуулах (ЕТ№50), анхны тусламжийн байр (ЕТ№53)-ын зориулалттай барилга байгууламжид Дорноговь** аймгийн Засаг даргын **2024** оны **09** дүгээр сарын **04**-ний өдрийн **А/650** дугаартай захирамж, шийдвэрээр байгуулагдсан **15** хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс **2024** оны **10** дугаар сарын **18**-ны өдрөөс эхлэн **1** хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

## ХОЁР.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний огноо: дугаар:

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: **ЭТ-25/18**

2.3. Захиалагч: Хуулийн этгээдийн хувьд: **Монгол улсын Сангийн яам** оноосон нэр, **9070005013** улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, хаяг: **Улаанбаатар** /нийслэл/, **Чингэлтэй** дүүрэг, **С.Данзангийн 5/1** гудамж, **Засгийн газрын 2 дугаар байр, Д корпус** /хашаа, хаалга/-ны дугаар, (976-51) 267468 холбоо барих, утас **info@mof.gov.mn** цахим хаяг;

2.4.Төсөл хэрэгжүүлэгч нэгж: **"Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төсөл** оноосон нэр, **9916679** регистрийн дугаар, хаяг: **Улаанбаатар** нийслэл, **Чингэлтэй** дүүрэг, **5 дугаар** хороо, **Самбуугийн гудамж, М-Плаза 1401** тоот /хашаа, хаалга/-ны дугаар, **70002555** холбоо барих утас, **info@diip.mn** цахим хаяг;

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч: **"Дөл бадам консалтинг" ХХК,** оноосон нэр, **9011820204** улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, **2-004/2021** зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийн дугаар, хаяг: **Улаанбаатар** нийслэл, **Хан-Уул** дүүрэг, **15-р хороо** гудамж, **Рапид харш 23-69 тоот** /хашаа, хаалга/-ны дугаар, **99243242, 89243242** холбоо барих утас, цахим хаяг;

2.5. Барилгын ажлын гүйцэтгэгч: **"Цац Орхон" ХХК** хуулийн этгээдийн оноосон нэр, **9011060101** Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, **5361796** регистрийн дугаар, **БУ11-1999/17** Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7-р хороо, 4 дүгээр хороолол 29-71 тоот /хашаа, хаалга/-ны дугаар, Утас:99107637, 99094669 Цахим хаяг

2.6.Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: **"Эрчим Төсөл" ХХК** хуулийн этгээдийн оноосон нэр, **9011423096** улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, **ЗТ19-117/21** зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, хаяг: **Улаанбаатар** нийслэл, **Сүхбаатар** дүүрэг **7-р** хороо, **Барилгын дэвшилтэт технологийн төв** гудамж /хороолол/ байр /хашаа, хаалга/-ны дугаар, **70135003** холбоо барих утас, цахим хаяг;

2.7.Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: **Гаалийн ерөнхий газрын харьяа Замын-Үүд дэх Гаалийн газар** оноосон нэр, **670001150** улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, **Дорноговь** аймаг, **Замын-Үүд** сум, **1 дүгээр** баг /хороо/, **Вокзал** гудамж /хороолол/ **өөрийн байр** /хашаа, хаалга/-ны дугаар, **99118439, 91914277** холбоо барих утас, info.zamiinuud@customs.gov.mn цахим хаяг;

2.8.Барилга байгууламжийн төлөв байдал: **Ашиглалтын шаардлага хангасан**

## ГУРАВ. ДҮГНЭЛТИЙН ХЭСЭГ

□ **Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:**

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

3.1.Энэхүү **Онцгой** төвөгшилтэй ангиллын **Хилийн Замын-Үүд боомт, ачаа тээврийн цогцолборын шатамхай бодисын агуулах (ЕТ№50), анхны тусламжийн байр (ЕТ№53)-ын** зориулалттай барилга байгууламж, холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комисоос ДҮГНЭСЭН нь:

3.2.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а).барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б).барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3.Ашиглагч байгууллагад:

а).барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б).барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в).барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4.Комиссын акт ...... хуудас, хуралдааны тэмдэглэл, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ...... хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох...... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

4.1. **Онцгой** төвөгшилтэй ангиллын **шатамхай бодисын агуулах (ETN№50), анхны тусламжийн байр (ETN№53)-ын** зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга: Ц.БАЯРМАА
(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Ц.БАТХҮҮ
("Дөл бадам консалтинг" ХХК-ийн өрөнхий менежер )

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын
гишүүний үүрэг даалгаврын биелэлтийн хуудсын хамт хүчинтэй.

---o0o---

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: ТХБХБТ
Албан тушаал: БХБХ-ийн дарга
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: 99653551

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. Агааржуулалтын системийг ашиглалтад оруулах туршилт тохируулга хийж, дараа нь актыг ашиглалтанд шилжүүлсэн акт | Хийгдсэн |
| 2. [illegible] хашааны [illegible] [illegible] [illegible] | Хийгдсэн |
| 3. [illegible] ТХБХБТ-ны ХБКМС-нд оруулах | Хийгдсэн |
| 4. Барилгын бичиг баримтын бүрдлийг бүрэн хангах | Бичиг баримтын архивт шилжүүлсэн байна |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь: Үүрэг даалгаврын биелэлтээр [illegible]

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
|---|---|
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| /Ц.[illegible]/ Гарын үсгийн тайлал | /Ц.[illegible]/ Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.10.18. | Огноо: 2024.11.02. |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: "Дон Бадрал ган семент" ХХК
Албан тушаал: Ерөнхий менежер
Комиссын гишүүн: Нэрийн Бат...
Холбогдох утас: 99070669

| Гишүүнд өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| ① Комиссын гишүүдийн үүрэг зөвлөмжийн биелэлтийг хангуулах. ② Зураг баримтын бүрдлийг хангах. | |

Шийдвэрлэсэн нь: [illegible]

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
| --- | --- |
| Гарын үсэг: [signature] | Гарын үсэг: [signature] |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / [signature] / Гарын үсгийн тайлал | / Б. Бак[illegible] / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024-10-18 | Огноо: 2024-11-12 |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН АНХНЫ ТУСЛАМЖИЙН БАЙРНЫ БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: "[illegible]" ХХК
Албан тушаал: Ерөнхий инженер
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: 99020669

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
| --- | --- |
| ① Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг хангах. ② Бичиг баримтын бүрдлийг хангах. | |

Шийдвэрлэсэн нь: Комиссын [illegible] үүрэг [illegible] [illegible] [illegible] [illegible] [illegible] авах

Үүрэг даалгавар өгсөн:

Гарын үсэг:

/Тамга, тэмдэг/

/ [illegible] / Гарын үсгийн тайлал

Огноо:

Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:

Гарын үсэг:

/Тамга, тэмдэг/

/ [illegible] / Гарын үсгийн тайлал

Огноо: 2019-11-12

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: [illegible]
Албан тушаал: [illegible]
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. [illegible] | Биелсэн |
| 2. [illegible] | [illegible] |
| 3. [illegible] | [illegible] |
| 4. [illegible] | |
| 5. [illegible] | Биелсэн ([illegible]) |
| 6. [illegible] | Биелсэн |

| | |
|---|---|
| 7. [illegible] барилгын бичиг баримт хувийн бүрдүүлж, тэдгээр архивын хадгалалтыг хянах.<br>8. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг зохион, гэрээ зургаар баталгаажуулах | Биелсэн<br><br>Биелсэн. (Гэрээ зургаар баталгаажуулсан |

Шийдвэрлэсэн нь: Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг баталсан

Үүрэг даалгавар өгсөн:

Гарын үсэг: [illegible]

/Тамга, тэмдэг/

[illegible] Гарын үсгийн тайлал

Огноо: [illegible]

Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:

Гарын үсэг: [illegible]

/Тамга, тэмдэг/

[illegible] Гарын үсгийн тайлал

Огноо: [illegible]

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

[illegible]

Байгууллага: [illegible]
Албан тушаал: [illegible]
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. [illegible] | Биелсэн |
| 2. [illegible] | [illegible] |
| 3. [illegible] | [illegible] |
| 4. [illegible] | Биелсэн |

Шийдвэрлэсэн нь: [illegible]

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
| --- | --- |
| Гарын үсэг: [signature] | Гарын үсэг: [signature] |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| [illegible] Гарын үсгийн тайлал | [illegible] Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2021.10.18 | Огноо: 2021.11.21 |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

**АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС**

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: [illegible]
Албан тушаал: [illegible]
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. [illegible] | [illegible] |
| 2) [illegible] | [illegible] |
| 3) [illegible] | [illegible] |
| 4) [illegible] | [illegible] |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь: Үүрэг даалгавар [illegible] [illegible] [illegible] -В-

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
|---|---|
| Гарын үсэг: [signature] | Гарын үсэг: [signature] |
| /Тамга, тэмдэг/ [stamp] | /Тамга, тэмдэг/ [stamp] |
| / / Гарын үсгийн тайлал | / / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024-10-18. | Огноо: 20[illegible] |

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах журмын 4 дүгээр хавсралт

**АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН АНХНЫ ТУСЛАМЖИЙН БАЙРНЫ БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС**

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: ЭМГ
Албан тушаал: ЭА [illegible]
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: 9011 7486

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1) суурийн суурь [illegible] засах. | хийгдсэн. |
| 2) хаалган [illegible] [illegible] [illegible] | хийсэн |
| 3) хоолойн [illegible] засах. | хийсэн. |
| 4) хаалга [illegible] [illegible] [illegible] [illegible] [illegible] засах | хийсэн |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь:

Үүрэг даалгаврыг [illegible]

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
|---|---|
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / /Гарын үсгийн тайлал | / /Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2021.10.18 | Огноо: [illegible] |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН АНХНЫ ТУСЛАМЖИЙН БАЙРНЫ БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: [illegible]
Албан тушаал: [illegible]
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: [illegible]

| Гишүүдэд өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. [illegible] | [illegible] |
| 2. ЦС-ийн [illegible] | [illegible] |
| 3. [illegible] | [illegible] |
| 4. [illegible] 0.4 кВ-ын [illegible] | [illegible] |

[illegible] [illegible]

[illegible]

Шийдвэрлэсэн нь: [illegible]

| | |
|---|---|
| Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ [illegible] / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.10.01. | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ [illegible] / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.11.12. |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: [illegible]
Албан тушаал: [illegible]
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
| --- | --- |
| 1. [illegible] | [illegible] |
| 2. [illegible] | [illegible] |
| 3. [illegible] | [illegible] |
| 4. [illegible] | [illegible] |

| | |
|---|---|
| [illegible] | [illegible] |

Шийдвэрлэсэн нь: [illegible]

| | |
|---|---|
| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт хангасан: |
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / [illegible] / Гарын үсгийн тайлал | / [illegible] / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.10.18. | Огноо: 2024.11.12. |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

## АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

/[illegible] биелэх/

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: ОБТ
Албан тушаал: ГТ ҮХБ
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: 99129000

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| [illegible] төлөвлөх. | [illegible] |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь:

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
|---|---|
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / Б.Нямцэрэн / Гарын үсгийн тайлал | / Б.Нямцэрэн / Гарын үсгийн тайлал |
| Огноо: | Огноо: |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: МХС ХХК-ийн Дорноговь аймгийн газар
Албан тушаал: Газрын дарга
Комиссын гишүүн: М. Наранцогт
Холбогдох утас: 9904 2606

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
| --- | --- |
| Хананд суурилуулагдсан рекны тавиурыг бэхлэх тоног төхөөрөмжүүдийг цэгцлэх | [illegible] хийж тоног төхөөрөмжүүдийг тавиурт байрлуулсан. |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь: [illegible] хүлээн авалаа [illegible]

Үүрэг даалгавар өгсөн:

Гарын үсэг:

Тамга, тэмдэг:

Гарын үсгийн тайлал

Огноо:

Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:

Гарын үсэг:

Тамга, тэмдэг:

Гарын үсгийн тайлал

Огноо: 2024 . 11 . 11

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН АНХНЫ ТУСЛАМЖИЙН БАЙРНЫ БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: МХС ХХК-ийн Дорноговь аймгийн [illegible]
Албан тушаал: Газрын дарга
Комиссын гишүүн: М. [illegible]
Холбогдох утас: 9904 3626

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
| --- | --- |
| Рекант суурилуулагдсан тоног төхөөрөмжүүдийг холбогдуулах | Холбогдуулсан [illegible] |

Шийдвэрлэсэн нь: Үүрэг даалгаврын биел[illegible] байгаа ашиглалтанд хүлээн авахад татгалзах зүйлгүй

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
| --- | --- |
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| М. Наран[illegible] Гарын үсгийн тайлал | М. Наран[illegible] Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.10.18 | Огноо: 2024.11.11 |

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: "Замын-Үүдийн ДС" ТӨҮГ.
Албан тушаал: Ерөнхий инженер.
Комиссын гишүүн: Д. Ган-Эрдэнэ.
Холбогдох утас: 990206[illegible].

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. Ажлын гүйцэтгэгчтэй акт бүрэн хийлгүүлэх. (Дулаан, цэвэр, бохир)<br>2. Холболтын шугамыг бүрэн хийлгэж дууссан акт хийлгэж гаргаж өгөх. | |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь: Үүрэг даалгавар биелэгдтэл байнгын анхааралдаа хяналт авах хэрэгтэй

| | |
|---|---|
| Үүрэг даалгавар өгсөн: [illegible] | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
| Гарын үсэг: [signature] | Гарын үсэг: [signature] |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / [illegible] / Гарын үсгийн тайлал | / [illegible] / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.10.18 | Огноо: 2024.10.18 |

[illegible]

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Замын-Үүд [illegible] газар
Албан тушаал: Галын [illegible] албаны дарга
Комиссын гишүүн: Г. [illegible]
Холбогдох утас: 91914291

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. Галын аюулгүй байдлыг хангах<br>- [illegible]<br>- Мэдрэгч [illegible]<br>[illegible], | Барилгын зураг төсөвт тусгагдаагүй, [illegible] болохгүй, |
| 2. Хашаа шаардлага хангахгүй | Зурагт тусгагдсан байсан. |
| 3. | |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн ажилтны үүрэг даалгаврын [illegible]

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
|---|---|
| Гарын үсэг: [signature] Г. [illegible] | Гарын үсэг: [signature] |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / / Гарын үсгийн тайлал | / 2024.10.25 / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.10.18 | Огноо: |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН АНХНЫ ТУСЛАМЖИЙН БАЙРНЫ БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Замын цагдаагийн газар (?)
Албан тушаал: Замын цагдаагийн газр[illegible] дарга
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| | |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь: Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг биелүүлэх [illegible] ашиглаж авах [illegible]

| | |
|---|---|
| Үүрэг даалгавар өгсөн: /Г. [illegible]/ | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / / Гарын үсгийн тайлал | / 2024.10.[illegible] / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.10.18 | Огноо: |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: [illegible]
Албан тушаал: [illegible]
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: 94780305

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| [illegible] | |

| | |
|---|---|
| | |
| Шийдвэрлэсэн нь: | Биелсэн [illegible] |
| Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.10.18 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

**АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН АНХНЫ ТУСЛАМЖИЙН БАЙРНЫ БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС**

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: ХХЗБ газар
Албан тушаал: [illegible]
Комиссын гишүүн: [illegible] Г.Энхтүр
Холбогдох утас: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| Гишүүнээс үүрэг даалгавар [illegible] биелүүлсэн | |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь: Байнга ашиглаж байх

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
|---|---|
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / Г. Дэлгэр / Гарын үсгийн тайлал | / Г. Дэлгэр / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.10.18 | Огноо: |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН АНХНЫ ТУСЛАМЖИЙН БАЙРНЫ БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: [illegible]
Албан тушаал: [illegible] инженер
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| Үүрэг даалгавар байхгүй | |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь: [illegible]

| | |
|---|---|
| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
| Гарын үсэг: [illegible] | Гарын үсэг: [illegible] |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / / Гарын үсгийн тайлал | / / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.10.19 | Огноо: 2024.10.25 |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: [illegible]
Албан тушаал: [illegible]
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| [illegible] | |

Шийдвэрлэсэн нь: [illegible]

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
| --- | --- |
| Гарын үсэг: [illegible] | Гарын үсэг: [illegible] |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / / Гарын үсгийн тайлал | / / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024 10.17 | Огноо: 2024 10.23 |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН АНХНЫ ТУСЛАМЖИЙН БАЙРНЫ БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Эрчим хүчний [illegible]
Албан тушаал: [illegible]
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1) Комисст гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтүүд.<br>2) [illegible]<br>3) [illegible] | |

| | |
|---|---|
| | |
| Шийдвэрлэсэн нь: [illegible] | |
| Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ [illegible] / Гарын үсгийн тайлал<br>Огноо: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ [illegible] / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2014. [illegible] |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

# АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХЫН БАРИЛГЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Эрчим [illegible] ХХК
Албан тушаал: Захирал
Комиссын гишүүн: [illegible]
Холбогдох утас: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. [illegible] төрлийн [illegible] гүйцэтгэсэн [illegible] зураг төслийн [illegible] [illegible]<br>2. Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн тохиолдолд барилгыг ашиглалтад хүлээн авна.<br>3. Барилгын архив [illegible] гүйцэтгэлийн баримтыг бүрдүүлэх. | |

| | |
|---|---|
| | |

Шийдвэрлэсэн нь:

[illegible]

Үүрэг даалгавар өгсөн:

Гарын үсэг:

/Тамга, тэмдэг/

/ [illegible] / Гарын үсгийн тайлал

Огноо:

Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:

Гарын үсэг:

/Тамга, тэмдэг/

/ [illegible] / Гарын үсгийн тайлал

Огноо: 2024.10.23

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах журмын 4 дүгээр хавсралт

**АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОРЫН ШАТАМХАЙ БОДИСЫН АГУУЛАХ, АНХНЫ ТУСЛАМЖИЙН БАЙРНЫ АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС**

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: "Дүц-оркон" ХХК
Албан тушаал: Менежер /Гүйцэтгэх захирал)
Комиссын гишүүн: Ө. Баярмаа
Холбогдох утас:

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| Саналгүй | |

Шийдвэрлэсэн нь: [illegible]

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
|---|---|
| Гарын үсэг: [illegible] / [illegible] | Гарын үсэг: [illegible] |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ / [illegible] / |
| / / Гарын үсгийн тайлал | / / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.10.18 | Огноо: 2024.10.18 |

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРХИВЫН ТАСАГ

## ТӨРИЙН АРХИВТ ЗУРАГ ТӨСӨЛ, ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГ ХҮЛЭЭН АВСАН АКТ

2024 оны 11 дүгээр сарын 21 өдөр № 59 Сайншанд сум

Монгол улсын Архив, албан хэтлөлтийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны а/650 дугаар захирамжийг үндэслэн "Цац орхон" ХХК-ийн зураг төслийн баримтыг аймгийн Архивын тасгийн сан хөмрөгт ........................................................ эрдэм шинжилгээний лавлахуудын хамт хүлээн авлаа. Үүнд:

| № | Баримт хүлээн авсан огноо | Барилга, байгууламжийн нэр | Боловсруулсан байгууллага, хүний нэр | Баримтын оны хязгаар | Баримтын иж бүрдэл | ХН-ээр | Хавтаст хэргээр | КТ-аар | Хуудсаар | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 1 | 2024.11.21 | Ачаа тээврийн цогцолборын Шатамхай бодисын агуулах, анхан тусламжийн байрны барилга угсралтын ажил | "Эрчим төсөл" ХХК | 2022-2024 | Бүрэн | 9 | | | | |

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН
"ЦАЦ ОРХОН" ХХК-ИЙН МЕНЕЖЕР Ө.БАЯРХҮҮ

ХҮЛЭЭН АВСАН:
АРХИВЫН ТАСГИЙН ДАРГА Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРХИВЫН ТАСГИЙН САН ХӨМРӨГТ ХҮЛЭЭН АВСАН ЗУРАГ ТӨСӨЛ, ТЕХНИКИЙН БАРИМТЫН БИЧГИЙН ЖАГСААЛТ № 59**

2024 оны 11 дүгээр сарын 21

1.**Захиалагчийн нэр**: "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төсөл
**2.Зураг төсөл боловсруулсан байгууллага:** "Эрчим төсөл" ХХК
**3. Барилгын ерөнхий гүйцэтгэгч:** "Цац орхон" ХХК
**4.Туслан гүйцэтгэгч:**
**5. Барилгын зориулалт**: Ачаа тээврийн цолцолборын Шатамхай бодисын агуулах, анхан тусламжийн байрны барилга угсралтын ажил
**6. Барилгын байршил, утасны №: Замын-Үүд боомт**: Утас:99107637

| № | Зураг төслийн нэр | Гол барилгын зураг төсөл Хуудасны тоо | | Дутуу зураг төсөл, баримтын нэр |
|---|---|---|---|---|
| 1 | Хувийн хэрэг | | | |
| 2 | Инженер геологийн судалгааны дүгнэлт | 23 | | |
| 3 | Ажлын төсөв | 88 | | |
| 4 | Ил, далд ажлын акт | 25<br>43 | | |
| 5 | Гэрэл зураг | - | | |
| 6 | Барилгын ажлын өдөр тутмын тэмдэглэл | 1 дэвтэр/24 хуудас | | Дутуу бөглөсөн |
| 7 | Ажлын зураг | ШБА | АТБ | |
| 8 | Өөрчлөлтийн зураг | - | - | |
| 9 | Загвар зураг | - | - | |
| 10 | ЕТ | | | |
| 11 | Гадна цахилгаан | | | |
| 12 | УХАТ | | | |
| 13 | БА /Барилга/ | 15 | 7 | |
| 14 | ББ /Барилга бүтэц/ | | 6 | |
| 15 | ЦУБ | | 4 | |
| 16 | ХАС | 14 | 7 | |
| 17 | ДГ /Дотор гэрэлтүүлэг/ | 1 | | |
| 18 | ХТ /Хүчит техээрэмж/ | 3 | 3 | Илүү хувьтай |
| 19 | Холбоо дохилол | | | |
| 20 | Гадна дулаан, ДМ | 2 | - | |
| 21 | Автомат удирдлага | | | |
| 22 | Гадна холбоо дохиолол | | - | |
| 23 | Барилгын гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн | 29 | | Орчуулга хийгдээгүй |

БАРИМТ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:
"ЦАЦ ОРХОН" ХХК-ИЙН МЕНЕЖЕР Ө.БАЯРХҮҮ

БАРИМТ ХҮЛЭЭН:
АРХИВЫН ТАСГИЙН ДАРГА Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр №  Замын-Үүд сум

Замын-Үүд боомтын Ачаа тээврийн хэсгийн 5 барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хурал 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Замын-Үүд дэх Гаалийн газрын оффисын барилгын хурлын танхимд болов.

Хурлыг комиссын дарга Ц.Баярмаа нээж, Дорноговь аймгийн Засаг даргын 2024 оны А/650 дугаар захирамжаар томилогдсон комиссын бүрэлдэхүүн Замын-Үүд боомтын Ачаа тээврийн цогцолборт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ариутгал халдваргүйтгэлийн барилга, Шатамхай бодисын агуулах, Анхны тусламжийн байр, Боомтын хяналтын бүсийн хашаа болон хаалга, Түргэн муудах бүтээгдэхүүний үзлэгийн байрны барилга байгууламжуудын ажлыг байнгын ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг танилцуулав.

Хуралд оролцсон нь:

**Комиссын дарга:**

Ц.Баярмаа (Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

**Нарийн бичгийн дарга:** Ц.Батхүү (Дэл бадам консалтинг ХХК-ийн Ерөнхий менежер бөгөөд Зөвлөх инженер)

**Гишүүд:**

Ч.Чулуунцэцэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга, Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч)

Н.Гарамжав (Аймгийн Засаг даргын тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Л.Бямбатуяа (Аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч

Б.Нямсүрэн (Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч)

П.Ням-Эрдэнэ ("Замын үүдийн дулааны станц" ТӨҮГ–н ерөнхий инженер)

М.Нарангэрэл ("Мэдээлэл холбоо сүлжээ" ХХК-н Дорноговь аймаг дахь салбарын дарга)

**Захиалагч байгууллага:**

Г.Дэлгэр ("Хилийн хөтөч-дэд бүтэц" төслийн хэрэгжүүлэх Нэгжийн менежер)

Г.Амарболд ("Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төсөл төслийн

хэрэгжүүлэх барилгын инженер)

Г.Чинзориг ("Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төсөл хэрэгжүүлэх

нэгжийн холбооны инженер)

**Ашиглагч байгууллага:**

Г.Удвалмядаг (Гаалийн ерөнхий газрын харьяа Замын-Үүд дэх

Гаалийн газрын Санхүү, аж ахуйн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан)

Г.Чинболд (Гаалийн ерөнхий газрын харьяа Замын-Үүд дэх

Гаалийн газрын аж ахуй хариуцсан зохион байгуулагч)

**Зураг төсөл зохиогч:**

Ц.Цогтжаа ("Эрчим төсөл" ХХК-ийн захирал)

**Гүйцэтгэгч:**

Э.Басхүү ("Гүнчимэгтэй" ХХК–ийн гүйцэтгэх захирал)

Г.Батзориг ("Гегатера" ХХК–ийн захирал )

Ө.Баярхүү ("Цац-Орхон" ХХК–ийн захирал)

Ц.Ганзориг ("Милдорф" ХХК-ийн захирал)

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

Замын-Үүд боомтын Ачаа тээвэр цогцолборын дараах 5 барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн санал дүгнэлтийг хэлэлцэх:

- Ариутгал халдваргүйтгэлийн барилга
- Шатамхай бодисын агуулах, Анхны тусламжийн байр
- Боомтын хяналтын бүсийн хашаа болон хаалга
- Түргэн муудах бүтээгдэхүүний үзлэгийн байр

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

**Л.Бямбатуяа:** /Аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч/

**1.Түргэн муудах бүтээгдэхүүний байр**

- Оффиссын зориулалтай өрөөний цонх хөлөрсөн байна. Шалтгааныг олж, засах
- Ариун цэврийн өрөөний агшин зуурын халаагчийн шугам хоолойг сайн бэхлэх ардаа зай ихтэй байна.

- Гадна хөрс доошоо суусан байна. Тэр хэсгийн суусан хөрсийг дүүргэн сайн нягтруулж өгөх.

Ариун цэврийн өрөөнд суултуурын почкиний ус их бага гарч буй учрыг олох

**2. Ариутгал халдваргүйтгэлийн барилга**

- Хаалганы гажааг засварлах
- Гадна үзлэгийн худгыг машин дайрсныг засварлах

**3. Анхны тусламжийн байр.**

- Суурь нь суулт өгөөд, пандус хаяавчны плита нь хуурч унасан унасныг засах.
- Хаалга ордог хэсгийн босго нь доошоо суугаад зай завсар гарсан байна. Энэ хэсгийг битүүлж янзлах
- Хаявчны хагарсныг засах
- Халаах хэрэгслийн кронштейн доош сууж засвартай болсныг засах

**4. Шатамхай бодисын агуулах**

- Хашааг зурагт заасны бетон суурьтай болгох, хашаа хоорондын завсар зайг битүүлэх
- Халаалтын системийн шугам хоолойноос ус гоожилтыг засах
- Агаар сэлгэх тоноглолыг бүрэн ажиллагаагаар хангах
- Агаар халаахад өгч байгаа дулаан шугамын зэвтэй хэсгийг будах

**5. Хашаа**

- Хашааны хувьд ашиглагч байгууллага үзэж шалгаад хүлээгээд авсан гэж ойлгож байгаа тул саналгүй байна.

**М. Нарангэрэл: /"Мэдээлэл холбоо сүлжээ" ХХК-н Дорноговь аймаг дахь газрын дарга/**

Комисс ажиллаж байгаа байгаа барилга байгууламжаар орж үзлээ. Урьд нь комиссоор барилга байгууламжуудын гадна шилэн кабелийн оруулгыг үзэж шалгаад хүлээж авсан. Дотор суурилуулсан тоног төхөөрөмжийн хувьд

**1.Түргэн муудах бүтээгдэхүүний байр**

- Тоног төхөөрөмжүүдийг нь раканд сул орхисон байна. Үүнийг холболтын гүйцээж цэгцэлж, хаягжуулах хэрэгтэй байна.

**2. Ариутгал халдваргүйтгэлийн барилга**

- Шинээр 65 м суваглал хийсэн байна. Далд ажлын актны зураг нь байхгүй байна. Зураг нэмж оруулах.
- Худаг суваглалаар кабель татсан актыг хавсаргах
- Сүлжээний тоног төхөөрөмжийг тавиур дээр сул орхисон холболтыг гүйцээж цэгцэлж хаягжуулах.

**3. Анхны тусламжийн байр**

- Раканд суурилуулагдсан төхөөрөмжүүдийг хаяглах

**4. Шатамхай бодисын агуулах**

- Хананд суурилагдсан ракны тавиурыг бэхлэж тоног төхөөрөмжүүдийг цэгцлэх

**5. Хашаа**

Хашааны хувьд ашиглагч байгууллага үзэж шалгаад хүлээгээд авсан гэж ойлгож байгаа тул саналгүй байна.

**П.Ням-Эрдэнэ: /Замын-Үүд дулааны станц" ТӨҮГ-н ерөнхий инженер/**

**1.Түргэн муудах бүтээгдэхүүний байр**

- Дулаан, цэвэр, бохирын усны угсралтын ажлын акт бүрдүүлэх
- Даралт болон температур хэмжүүрийн баталгаажуулалтын ажил хийж гэрчилгээг нь хавсаргах
- Дулааны болон цэвэр усны оруулгын шугам лацдаж тайлан гаргах
- Дулааны узель хаягжуулж, урсгалын чиг тавих

**2. Ариутгал халдваргүйтгэлийн барилга**

- Гадна бохирын худагт цэвэрлэгээ үйлчилгээ хийж тагийг хүчитгэж солих
- Даралт болон температур хэмжүүрийн баталгаажуулалтын ажлыг хийж, гэрчилгээг нь хавсаргах
- Манай байгууллагаас нэгдсэн дулаанаа аваад жил гаран болж байгаа тул тооцоо нийлж төлбөрийг асуудлаа бүрэн шийдвэрлэх шаардлагатай.

**3. Шатамхай бодисын агуулах, Анхны тусламжийн байр**

- Угсралтын ажил гүйцэтгэлийн акт нэг ч байхгүй байна. Акт үйлдсэний дараа дахин үзэх шаардлагатай.
- Ямартай ч туршилтын журмаар халаалтаа түр авсан юм байна. Тэгэхээр үүнтэй холбоотой төлбөр тооцооны асуудлаа манай байгууллагатай хийж дуусгах.
- Халаалт аваагүй гэж байгаа тул шугамаа юулж байх үеийг фото зургаар баталгаажуулж лацдаж тайлан ирүүлэх.

**4. Хашаа**

Хашааны хувьд ашиглагч байгууллага үзэж шалгаад хүлээгээд авсан гэж ойлгож байгаа тул саналгүй байна.

**Н.Гарамжав: /Аймгийн Засаг даргын тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч/**

**1.Түргэн муудах бүтээгдэхүүний үзлэгийн байр**

- Зургийн дагуу ГС-г угсрах
- Цахилгааны самбаруудад нэр хаяг, кабелийн вирх бичих, АА-ны санамж, плакат хийх
- ХС-1, ХС-2 суурьгүй юм байна тэгэхээр доогуур нь ил харагдаж байгаа кабелийг эмх цэгцтэй болгож хаалт хамгаалалт хийж өгөх.
- Дотор цахилгааны актанд ф2,5 хөндлөн огтлолттой гэж бичигдсэн байна. Хүчит тоноглолын хэсэгт ф4 хөндлөн огтлолтой утас татсан гэсэн тул актыг үнэн зөв гүйцэд бичиж фото зураг хавсаргаж үзүүлэх.
- Таталтын хайрцаг гэж төсөвт байна. Яагаад хийгээгүй талаар тайлбар ирүүлэх шаардлагатай.

**2. Ариутгал халдваргүйтгэлийн барилга**

- Ил далд ажлын акт байхгүй тул фото зургаар баталгаажуулж бичих
- ХС-ийн нэр хаяг, кабелийн вирх схем, АА-ны санамж, плакат хийх.

**3. Анхны тусламжийн байр**

- Дотор цахилгааны самбар зургаас өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн зургаар баталгаажуулах
- ХС-ийн нэр хаяг, кабелийн вирх схем, АА-ны санамж, плакат хийх, хаалга хаагдахгүй байгааг засварлах
- Ил далд ажлын акт байхгүй фото зургаар баталгаажуулах
- Барилгын аянга зайлуулагч 0,4квт цахилгаан самбарын газардуулгын акт мэргэжлийн байгууллагаар хянуулж баталгаажуулах

**4. Шатамхай бодисын агуулах**

- Гадна байрлах оролтын самбарын хаалганы битүүмжлэл сайжруулах
- Цахилгааны самбаруудын цэнэг шавхагч, холболтыг гүйцээх, нэр хаяг, вирк, схем, АА-ны санамж плакат хийх, ашиглалтын заавар бичиж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх
- Удирдлагын самбарын залгах, салгах гэх мэт хаягжуулалт хийх
- Зургаас өөрчлөгдсөн самбаруудыг гүйцэтгэлийн зураг гаргаж баталгаажуулах

- Ил далд ажлын акт байхгүй байгаа тул гүйцээж бичих
- Барилгын аянга зайлуулагч 0.4квт цахилгааны самбаруудын газардуулгыг мэргэжлийн байгууллагаар хэмжүүлж баталгаажуулж акттай хавсаргах.

**5. Хашаа**

Хашааны хувьд ашиглагч байгууллага үзэж шалгаад хүлээгээд авсан гэж ойлгож байгаа тул саналгүй байна.

**Ч.Чулуунцэцэг: /Аймгийн Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга, Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч/**

**1.Түргэн муудах бүтээгдэхүүний үзлэгийн байр**

- Ил, далд ажлын актын бүрдэл хангах огноо, дугаарыг гүйцээж бичих
- Ил, далд ажлын актын гэрэл зургуудыг фото цаасан дээр буулгаж, хаяг тайлбар бичих
- Захиалагчаас холбогдох баримт бичгийн эх хувийг авах, эх хувиар аваагүй тохиолдолд хуулбар үнэн тамга даруулах
- Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн ажлын тэмдэглэл байхгүй байна. Бүрэн бичиж, баталгаажуулсан тэмдэглэлийг төрийн архивт өгөх
- Ашигласан материалын гарал үүслийн гэрчилгээ бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтыг баталгаат орчуулгын газраар орчуулж хавсаргах.

**2. Ариутгал халдваргүйтгэлийн барилга**

- Ил далд ажлын актанд /Цогт, Жаргалсайхан/ гарын үсэг зурж баталгаажуулах
- Ажлын зураг эх хувь захиалагчаас авах
- Хувийн хэрэгт байгаа ИТА дипломыг дахин тодоор сканердаж хийх
- Барилга угсралтын ажлын гүйцэтгэсэн ажлын тэмдэгдэглэл бүрэн бичиж ирэх баталгаажуулах
- Барилгын ил далд ажлын гэрэл зургууд бүрдүүлж фото цаасан дээр буулгаж хаяг тайлбар бичих
- Барилга угсралтын зураг төслийн баримт бичиг эх хувиар бүрдүүлж төрийн архивт хүлээлгэн өгөх.

**3. Анхны тусламжийн байр.**

- Ил далд ажлын актыг бүрэн бичиж баталгаажуулах
- Ил далд ажлын гэрэл зургийг үе шат бүрээр бүрэн бүрдүүлж, фото цаасан дээр буулгах
- Барилгын ажил гүйцэтгэсэн ажлын тэмдэглэлийг баталгаажуулах
- Дээрх баримт бичгийг эх хувиар төрийн архивт хүлээлгэн өгөх

**4. Шатамхай бодисын агуулах**

- Ил далд ажлын актыг бүрэн бичиж баталгаажуулах
- Барилгын ил далд ажлын гэрэл зургийг үе шат бүрээр бүрдүүлж, фото цаасан дээр буулгаж, хаяг тайлбар бичих
- Барилгын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл байхгүй байгаа тул бүрэн бичиж баталгаажуулж төрийн архивт өгөх
- Ажлын зургийг эх хувиар хүлээн авна.
- Хувийн хэрэгт бүрдүүлсэн бүх баримт хуулбар байна. Баримт бичгийг эх хувиар бүрдүүлнэ. Хуулбар баримтанд "хуулбар үнэн" тэмдэг даруулах
- Ажил гүйцэтгэх гэрээний үнийн дүнтэй улаан тамгатай тендерт оролцоход санал болгосон гэрээний үнийн дүнтэй ажлын төсвийг авна. Энд бол магадлал хийлгэсэн төсөв харагдаж байсан. Тэр төсөв бол биш шүү.
- Барилгын зураг төслийн баримт бичгийг эх хувиар бүрдүүлж, төрийн архивт хүлээлгэн өгөх

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж, гэрэл зургаар баталгаажуулах.

Архивт нэгж олгох асуудал нь архивын ерөнхий газрын даргын баталсан зураг төсөл техникийн бичиг баримттай ажиллах ажлын заавар байгаа тэр зааврын дагуу хадгаламж нээж архивт хүлээлгэн өгнө.

**Г.Удвалмядаг:**

1.Түргэн муудах бүтээгдэхүүний үзлэгийн байрны талаар эхлээд зургийн автороос хэдэн зүйл тодруулж асууя.

Тусгай зориулалтын түргэн муудах бүтээгдэхүүний агуулах, тэсэрч дэлбэрэх бодисын агуулах, халуун хүйтэн агуулах гээд баахан агуулахууд байдаг энэ нь бусад барилга байгууламжуудаас юугаараа ялгаатай юм бэ? Комисс ажиллах үед ирээд үүрэг даалгавар өгөөд, хүлээгээд явдаг. Тэр нь яг ашиглаад ирэнгүүт саравчин доогуур нь ачаатай машин багтдаггүй, пүү нь дээр нь урт машин гарахаар тэгнэдэг тэрийг нь Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл манай 2 хүн гүйж засварлаж янзалдаг. Тэгээд улсын комисс гэж нэг бөөн бөөнөөрөө цуглаад баахан үүрэг даалгавар өгөөд тараад явдаг ард нь ашиглагч гээд бид нар үлддэг. Тэр үед нь гүйцэтгэгч нарт хэлэхэд батлагдаад ирсэн зураг нь ийм л байсан бид батлагдсан зураг төсвийн дагуу л гүйцэтгэж байгаа гэдэг хариулт өгдөг. Тэгээд зураг төслийн харахаар үнэхээр л ийм байдалтай зурагдаад ирсэн байдаг. Жишээ нь:

**Түргэн муудах бүтээгдэхүүний агуулах** гэхэд л хүнсний бүтээгдэхүүн эм, эмнэлгийн хэрэгсэл гэх мэтчлэн дандаа хүний эрүүл мэндтэй холбоотой бараа бүтээгдэхүүн л шалгана. Гэтэл энэ дотор нэг ч хэрэгтэй техеөрөмж байхгүй ялангуяа зуны 37-38 хэмийн халуунд нэг өдрийн дотор шалгаад дуусахгүй бол энэ бүтээгдэхүүнийг хөргүүрт хийж байж маргааш нь үргэлжлүүлээд шалгах хэрэгтэй болно. Гэтэл энд нь хөргүүр байна уу байхгүй. 2023 онд авсан зорчигч тээврийн цогцолборт баригдсан баруун зүүн 2 агуулах нэг нь шинээр ашиглалтанд орсон. Нөгөөх нь засвар хийгдсэн хүйтэн агуулах гэж байгаа гэтэл тэр дотор хэрэгтэй нэг ширхэг ч техеөрөмж байхгүй. За тэгээд хурааж авсан мах гэдэс, өлөн гэдэс бүгд муудаад тэрүүгээр нэг өмхий самхай болж бид өөрсдөө цэвэрлэж авсан. Үүний дараагаар гааль өөрөө тэндээ зарлаж нэг юм хөргүүр тавиулсан. Ийм ийм хүндрэл байна гээд зургийн байгууллагад хэлэхээр Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн ерөнхий газраас боловсруулж өгсөн зургийн даалгаврын дагуу бид зураг төслөө боловсруулсан гэдэг хариултыг өгдөг. Миний хувьд зураг төслийн байгууллагад Түргэн муудах бүтээгдэхүүний агуулах гээд захиалахаар түүнд шаардлагатай бүх зүйлийг л тусгаж өгөх боловуу гэж бодож байна. Миний хувьд бол би барилгын мэргэжлийн хүн бол биш гэхдээ Түргэн муудах бүтээгдэхүүний агуулах гэж байгаа юм чинь нэгдүгээрт хөргүүр баймаар цаашлаад эм, эмнэлгийн тоног төхөөрөмж хүнсний бүтээгдэхүүн шалгах юм чинь тоос шороо босдоггүй будаг шунх сонгомоор санагдах юм. Энэ дээр одоо манай улсын комисоос шалгах юм байна уу. Тоос шороо нь хэр байна гэх мэтчлэн стандарт тохирсон байна уу үгүй юу, багаж хэрэгсэл байна уу гэх мэтчлэн ярьвал их юм байна. Мөн түргэн муудах бүтээгдэхүүний агуулах гэхэд галын гидрант ус шүрших нэг ч зүйл алга. Одоо бүх зүйл смарт болсон хрант онгойлгохоос өмнө утаагаа мэдрээд шууд шүршдэг болсон үг нь бол ийм зүйл тавьж өгөх ёстой байтал энэ биттий хэл ус шүрших шланг ч байхгүй байна. Энэний хариуцлагыг хэн хүлээх бэ.

**2. Ариуттал халдваргүйтгэлийн барилга**

- Гадна зам талбай энэ тэр нь засварлахгүй бол ачаатай машин тэрэг унаж байна.
- Тэр 2 хаалга нь ямар ч гэсэн ачаатай машин орж л байгаа боловч том оврын ачаатай машин орж ирэхэд багтах ямарч боломжгүй байна. Жишээн нь: Уул уурхайн тоног төхөөрөмж, барилгын тайрч тасалж болдоггүй овор ихтэй ачаа бараа гэх мэтчлэн. Энэ талыг захиалагч байгууллага өөрсдөө сайн анхаарч үзээрэй.

- Гүйцэтгэгч байгууллагын хувьд ч яахав зураг төслийн дагуу хийчихсэн болохоор ийм тийм гэж болохгүй юм. Нөгөө зураг төсөл дээр нь ариутгалтай холбоотой нэг ч тоног төхөөрөмж байхгүй байна.

**3. Анхны тусламжийн байр.**

- Энэ дээр тухайлсан санал байхгүй.

**4. Шатамхай бодисын агуулах**

- Сая мэргэжлийн хүн нь хашааны талаар хэлчихлээ. Засварлаж өгөх хэрэгтэй.
- Галын аюултай холбоотой асуудлыг шийдвэрлэж л өгөх хэрэгтэй байна.

**5. Хашаа**

Хашааны хувьд ашиглагч байгууллага хүлээгээд авсан гэж ойлгож байгаа тул саналгүй байна.

**Г.Дэлгэр:**

Гүйцэтгэгч 4 байгууллагад тухайлсан саналгүй байна. Улсын комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг маш сайн чанартай биелүүлэх хэрэгтэй байна. Хамгийн гол нь богино хугацаанд хийх хэрэгтэй байна. Учир нь: Засгийн газрын тогтоол гарчихсан 10 сарын 31 гэхэд он дамнасан ажлуудыг шахаж яаралтай дуусгахгүй бол төсөв татагдаж гүйцэтгэгч байгууллагуудад хариуцлага тооцно гэсэн. Тийм учраас маш хариуцлагатайгаар комисс дээр онцгой анхааруулж хэлж байна. Тийм учраас энэ хугацаандаа амжихгүй бол гүйцэтгэгч байгууллагууд өөрсдөдөө гомдоорой.

Гаалийн санхүү хэлтсийн даргын хэлж байгаа асуудал бол гарцаагүй үнэн асуудал. Миний хувьд сүүлийн 10 гаруй жил барилга байгууламжтай холбоотой ажил хийж байна. Төсөл бүр дээр барилга байгууламжийн зураг төсөлтэй холбоотой асуудал асар их гарч байна. Хэрэндээ боломжоороо төсөвтэй уялдуулаад гүйцэтгүүлж ирсэн.
Ямартай ч энэ том төслийн ард зураг төслийн "Очиртаав" ХХК, "Эрчим төсөл" ХХК-тай хамтраад ард нь гарлаа. Энэхүү хугацаанд ашиглагч гүйцэтгэгч хяналтын байгууллагууд нь сэтгэлтэй тулдаа боломжийн хэрээр гүйцэтгээд өнөөдрийн хэмжээнд хүрч байна. Энэ төсөл дээр хамтран ажилласан бүх албан байгууллагадаа ажилчидаа маш их баярлалаа гэж хэлмээр байна.

**Ц.Цогтжав:**

Бүгдэд нь энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Миний хувьд бол саналууд ерөнхийдөө давхцаж байна. Хамгийн гол нь гүйцэтгэгч байгууллагууд бичиг баримтаа сайн цэгцлээрэй.

**1.Түргэн муудах бүтээгдэхүүний үзлэгийн байр**

- Цахилгаан холболтын вирк, хаягжилтыг гүйцээх
- Холигч, узель, усны хэрэглээний тэжээлийг холбож өгөх
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийн дагуу байнгын ашиглалтанд авах саналтай байна.

**2. Ариуттал халдваргүйтгэлийн барилга**

- Ил далд ажлын акт байхгүй фото зургаар баталгаажуулах
- ХС-ийн нэр хаяг, кабелийн вирк схем, АА-ны санамж, плакат хийх.

**3. Анхны тусламжийн байр.**

- Дутуу хийсэн ажлуудаа гүйцээгээд богино хугацаанд дуусгах хэрэгтэй байна.
- Хамгийн чухал зүйл чинь гүйцэтгэлийн бичиг баримтын бүрдүүлэх

**4. Шатамхай бодисын агуулах**

- Өөрчлөлт гарсан хэсэгт гүйцэтгэлийн зураг гаргаж зохиогчтой зөвшилцөх
- Архивт хүлээлгэж өгөх бичиг баримтыг бүрдүүлэх.

**5. Хашаа**

Хашааны хувьд ашиглагч байгууллага хүлээгээд авсан гэж ойлгож байгаа тул саналгүй байна.

Эцэст нь Гаалийн газрын Удвалмядаг даргын асуултанд боломжоороо хариулт өгөхийг хичээе.

2018 онд Энэхүү бүтээн байгуулалтын сонгон шалгаруулалтын ажил зарлагдаж зохион байгуулагдсан. Энэ сонгон шалгаруулалтын тендерт "Очиртааб", "Эрчим төсөл" гэдэг 2 байгууллага нэг нь зорчигч тээвэр, нөгөөх нь ачаа тээврийн цогцолбор байгууламжууд дээр зураг төсөл боловсруулахаар сонгогдсон. Энэний дагуу манай байгууллага Гаалийн ерөнхий газраас Болд-Эрдэнэ гэж газрын дарга байсан, Мэргэжлийн хяналтын газар, Сангийн яам, Хил хамгаалах ерөнхий газар захиалагч зэргээс бүрдсэн ажлын хэсэгт манай байгууллагын зүгээс эскиз зураг төслийг боловсруулж танилцуулсан. Үүний дагуу холбогдох байгууллагууд саналаа хэлж олон шат дамжлагаар энэ зураг төсөл гэдэг зүйл зохиогддог. Тэрнээс биш миний санал хүсэлтээр хийгдчихдэг ажил биш. Анхны хил орчмын бүсийн том төсөл аль аль талдаа алдаа дутагдал ихтэй байсан байх. Манай зүгээс зураг төслийн даалгавар өгөхдөө галын улаан шугаман дээр ажиллаж байгаа ашиглагч байгууллагуудаасаа саналын сайн аваарай урьд гарсан алдаа дутагдлаа давтмааргүй байна гэж хэлээд л байсан. Тэгэхгүй бол тэр дээр сууж байгаа дарга цэрэг нар газар дээрх асуудлаа сайн мэдэхгүй гоё ганган талын юм л тусгаад зургийн даалгаварыг өгдөг юм шиг байна. Миний хувьд ч гэсэн би зургийн даалгаавар, зааврын дагуу л зураг төслөө боловсруулж холбогдох хүмүүсээр нь батлуулаад л гүйцэтгэсэн тэрнээс биш хүн болгонд чичлүүлэхээр зүйл бол хийгээгүй гэж бодож байна.

Шатамхай бодисын агуулахад яагаад галын гидрант тавьсангүй вэ гэж байна. Энэ ч бас мөн адил БНбД улаан хавтастай ном байгаа. Энэ нь манай байгууллагын зүгээс баримтлах ямарч өөрчлөлт орохгүй баримт бичиг байдаг. Энэ дээр 5000 м3 эзэлхүүнтэй барилга байгууламж дээр захиалагч тусгайлан шаардлага тавиагүй бол тавих шаардлагагүй гэсэн заалт байдаг. Бидний зүгээс тухайн үед нь асуугаагүй биш асуусан. Тэгэхэд норм чинь юу байгаа юм гэдэг тэрний дагуу нормоо хэлсэн. Тийм учраас та бүгд бид нар пуу ярих биш удирдлагуудаа энэ асуултуудаа тавих шаардлагатай болов уу гэж бодож байна.

**Ц.Батхүү: "Дөл бадам консалтинг" ХХК-н Ерөнхий менежер**

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелэлтийг хангуулах тал дээр анхаарч ажиллах болно. Бичиг баримтын бүрдлийн хувьд бол бүх гүйцэтгэгч байгууллагуудад маш олон удаа анхааруулж шаардаж ирсэн. Яг үнэнийг хэлэхэд сүүлдээ гүйцэтгэгч байгууллагуудтай холбоо барих гээд утас шөрмөсөө ч авахаа байсан. Осолгүй комисс ажиллаж байна гэхэд л нэг юм цугларч байна. Удахгүй улсын комисс ажиллах гэж байна бүрдүүлсэн материалаа шалгуулаад ойлгомжгүй зүйл дээрээ зааавар зөвлөгөө ав гээд байхад нэг ч хүн ирэлгүй өнөөдрийн байдалд ирсэн үнэхээр харамсалтай байна. Манай байгууллагын хувьд ч хүний өмнөөс ингэж сууж байгаа нь зөвгүй л байна. Бидний зүгээс гэрээгээр хүлээсэн ҮҮргээ ухамсарлаад хийх ажлаа цаг хугацаанд нь хийж бүрдүүлэх бичиг баримтаа бүрдүүлээч гээд байхад нэмэргүй өнөөдрийг хүрлээ. Манай байгууллагын зүгээс бол үе шатны санхүүжилтан дээр шахаж шаардаж байгаад бичиг баримтын бүрдлийн хангуулаад явуулдаг. Энд үе шатны ажилбар дуусан бол актаар баталгаажуулаад дуусаагүй ажилбаруудын фото зургаар баталгаажуулж хавсаргаж ирсэн. Гэдэл өнөөдрийн хувьд бол гүйцэтгэгч байгууллагуудын хувийн хэрэг болон гүйцэтгэлийн бичиг баримтууд бол үнэхээр шаардлага хангахгүй байна. Тийм учраас комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж бичиг баримтаа иж бүрэн бүрдүүлж ирж шалгуулах хэрэгтэй.

Удвалмядаг даргын хэлсэнтэй холбоотой барилгын зураг бол үндсэн барилгын хийцлэлтэй холбоотой холбоотой зураг л зурагдаж байна. Зураг төслийн байгууллагууд нь тусгай зориулалтын барилга байгууламжууд дээр тоног төхөөрөмж хэрэгслийн судалгаа хийж тоног төхөөрөмж дээр нь төсөв зурагт оруулж өгөх байсан жишээ нь Ариутгал халдваргүйтгэлийн

барилга гэсэн байхад үүнд ямар ямар тоног төхөөрөмж шаардлагатай хэрхэн суурилуулах, мөн халуун хүйтэн агуулах гэхэд хэрэглэлтийн төхөөрөмж хэдэн градус байх гэх мэтчлэн нэг бүрчлэн зураг төсөөт тусгаж өгөх байтал зургийн байгууллага нь зөвхөн суурь, барилга бүтээцийн зураг төсөл боловсруулж экспертээр батлуулсан. Манай зүгээс бол экспертээр ороод батлагдсан зураг, төсвийн дагуу захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж байна.

**Дэлгэр:Хөгжлийн хөтөч дэд бүтэц нэгжийн төслийн менежер**

Энэ дээр бие нэг тайлбар хэлье. 2018 онд зураг төсөл хийгдэнэ байхад мэргэжлийн хяналтын байгууллагаас тоног төхөөрөмжүүдийг манай байгууллага өөрсдөө сонгон шалгаруулалтыг хийнэ гэж хэлсэн.

Гүйцэтгэгч байгууллагууд дээр тухайлсан санал бол байхгүй.

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангуулж байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

**Ц.Баярмаа:**

**1. Шатамхай бодисын агуулах**

- Колирфелийн систем, агааржуулалтын системийг бүрэн ажиллагаанд оруулж туршилт тохируулгын хийгээд ашиглалтын заавар бэлдэж өгөх.
- Хашааны хувьд зураг дээр зурагдсан болоеч төсөв нь ажлын хөлс тооцогдсон байна. Энэ яагаад төсөв дээрээ хуучин хашаа хийнэ гэж оруулсан энэ тал дээр тайлбар албан ёсоор өгөөрэй.
- Төсөв дээр хашаа хэдий байхгүй байсан ч гүйцэтгэгч байгууллага нь ямартай ч хашаатай байх ёстой гээд хашаа хийж өгсөн нь талархууштай хэдий ч өнгө үзэмжийн сайруулаад цэгцлэх юм бас байна эдгээрийгээ засаж цэгцлээд шалгуулах.

**2. Анхны тусламжийн байр**

- Тухайн барилгын хувьд яг л зураг төслийн дагуу хийгдсэн байна. Мөн л зураг төслийн дагуу учир дотор тоног төхөөрөмж нь тусгагдаагүй байна.

**3. Түргэн муудах бүтээгдэхүүний үзлэгийн байр.**

- Ил, далд ажлын актын бүрдэл хангах
- Барилгын материалын үлдэгдэлийг бүрэн зөөвөрлөж, барилгын гадна болон дотор цэвэрлэгээ хийх
- Барилгын гадна шугамын гүйцэтгэлийн зураг гаргаж ГХБХБ-ын ХБХМС-д бүртгүүлэх
- Нормчлолын сангийн төлбөрийг БХТ-н дансанд төлөх
- Дотор халаалтын системийн туршилт, тохируулга хийсэн акт үйлдэх

**4. Ариутгал халдваргүйтгэлийн барилга**

- Ил далд ажлын акт бүрдлийг хангах /гарын үсэг огноо бүрэн зөв байх/
- Гүйцэтгэлийн зураг гаргаж ГХБХБГ-ийн ХБКМС-нд бүртгүүлэх

**Эцэст нь дүгнэж хэлэхэд:** Замын-Үүдийн Гаалийн цогцолборт баригдсан барилга байгууламжуудыг ашиглалтад хүлээн авах комиссыг сүүлийн 2 жил ахалж ажиллах явцад зураг төслийг дутуу боловсруулснаас шалтгаалж, ашиглалтын явцад үүсэх хүндрэлтэй асуудал их байна. Энэ дагуу тодруулахад захиалагч тал болох "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч "Дөл бадам консалтинг" ХХК-ны зүгээс экспертээр ороод батлагдсан зургийн дагуу гүйцэтгүүлж байна гэдэг. Тэгээд зураг төслийн хувьд яг зургийн дагуу л байдаг. Үг нь бол зургийн даалгаврыг хичнээн тэгж өгч байгаа ч гэсэн зураг төслийн байгууллага нь өөрсдөө судалгаа хийгээд, ийм байдаг юм байна гэж яагаад саналаа хэлдэггүй юм бэ. Тэр дарга нараас санал авч болно, тэр дарга л тэгсэн гэсний дагуу зураг зурна гэдэг нь өөрөө учир дутагдалтай байна гэж миний хувьд бодож байна.
Миний хувьд нэг шүүмжлэлтэй байгаа асуудал нь энд баригдсан барилга байгууламжууд бүгд магадлалаар хянагдсан зураг төсөлтэй, манай улсын хувьд Барилга хөгжлийн төв гэж

байгуулага улсын хэмжээнд ганцхан магадлал хийх эрх бүхий байгууллага байдаг. Энд дандаа Монгол улсын эксперт зөвлөх хүмүүс магадлал хийдэг. Энэ хүмүүс яагаад мэргэжлийн бус хүмүүсийн саналын дагуу зурчихаад тэрийг нь магадлаад байгаа нь бас хачирхалтай. Манайх өөрөө захиалагчийн хяналт хэрэгжүүлдэг байгууллага. Хүндрэлтэй асуудлууд маш их гарч ирдэг эцэс сүүлд нь хяналт тавьсан байгууллага буруутан болдог. Аймгийн хэмжээнд болохоор Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу Газрын харилцаа, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга өмчийн хэлбэр хамаарахгүйгээр нутаг дэвсгэрийн хэмжээнд баригдсан бүх барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссыг ахалж байгаа. Миний хувьд болохоор эдгээр барилга байгууламжийн барилгын зураг төслийг хянах болон гүйцэтгэхэд оролцоогүй. Хяналтыг нь ч хэрэгжүүлж байгаагүй комисс ажиллах болохоор нэг өдөр өдрийн хагаст л ажиллаад энэ олон барилгыг хүлээж авч байна. Тал талын мэргэжлийн байцаагч нарыг албан тушаалаар нь засгийн газрын тогтоолоор томилчихсоны дагуу аймгийн Засаг даргын захирамж гараад ирж байгаа юм. Үнэхээр учир дутагдалтай юм их байгаа тэгээд хэлэхээр зургийн дагуу ингэж хийсэн гэдэг тайлбартай. Тэгээд л нүдэнд харагдсан учир дутагдалтай зүйлсийг засуулах бичиг баримтын бүрдлийг хангуулах үүрэг даалгавар өгөөд л комиссын актан дээр гарын үсэг зуруулаад би комиссыг ахлаад л явж байна. Дараа нь нэг асуудал гараад жишээ нь гал түймэр гардаг ч юмуу газар хөдөлдөг ч юмуу асуудал гарлаа гэхэд комиссыг ахалсанаараа хамгийн түрүүнд дуудагдах гээд байдаг. Энэ бол маш эрсдэлтэй ажил миний хувьд над дээр ийм хариуцлага байгаа гээд олон удаа буцаагаад няцаагаад байгаа боловч зураг төсөл нь ийм гүйцэтгэгч байгууллага нь бид зургийн дагуу хийж гүйцэтгэсэн. Гэсэн нэг ийм байдалтай байдаг энэ нь Монгол улсад жишиг боллоо. Надтай ижил ийм албан тушаалыг хашиж байгаа 21 аймгийн барилга хэлтсийн дарга нар хоорондоо энэ асуудлаар байнга ярилцдаг боловч шийдэл байдаггүй. Мэргэжлийн хяналт гэдэг газар нь татан буугдсан. Байхдаа бол уул нь мэргэжлийн олон асуудлыг хариуцсан тал бүрийн мэргэжлийн байцаагч нараас бүрдсэн нэгдсэн удирдлагатай байсан болохоор маш их нэмэр дус дэмтэй байсан. Одоо тараагаад бутраачихсан жил ирэх тусам л барилгын чанар муудаж байна гэж хувь хүнийхээ үүднээс дүгнэдэг. Энэ том төслийг хэрэгжүүлж байгаа /энэ бол хувийн хөрөнгөөр баригдсан хувийн өмч биш/ улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа хил гаалийн том цогцолбор болон өргөжин баригдаж байгаа барилга байгууламж. Энэ том объект 2018 оноос хойш барилгын зураг төсөл нь хийгдээд явж байгаа өнөөдөр 2024 он бүхэл бүтэн 6 жил хэрэгжээд ирсэн өнөөдөр ингээд ашиглалтанд хүлээж авах гээд улсын комисс ажиллаж байна. Гаалийн Удвалмаадаг даргын хэлээд байгаатай бол санал нийлж байна үнэхээр ашиглая гэхээр ашиглах боломжгүй дахиад нэмэлт хөрөнгө дандаа шаардана. Жишээ нь саравч өндөрлөх ч юмуу олон асуудлууд гарч ирээд байгааг хүлээн зөвшөөрч байна. Энийг анхнаасаа тэр зураг төсөл боловсруулахдаа зургийн даалгавар боловсруулахдаа захиалагч байгууллага болох Сангийн яамны дэргэд "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл гэж төслийн нэгж үүсгээд зорчигч тээвэр дээр Барилга хөгжлийн төв гээд Монгол улсын хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлж байгаа ганц төсвийн газар энд хяналт тавиад хэрэгжүүлж байгаа. Сүүлдээ тэрнээсээ болиод "Дэл бадам консалтинг" ХХК гээд барилгын яамнаас тусгай зөвшөөрөл авчихсан зөвлөх үйлчилгээний ийм байгууллага байгаа. Одоо эцсийн бүлэгтээ ашиглагч байгууллагад л хүндрэл учирлаа гүйцэтгэгч байгууллага болохоор нэмэлтээр хийх ажил нь зураг төсөвт байхгүй та бараг шантаачиллаа АТГ өгнө энэ тэр гээд асуудал бол дуусахгүй. Үнэхээр л зураг төсөвт байхгүй зүйлийг яах ч билээ энэ асуудал бол шийдэгдэхгүй л үлдэж байгаа. Тэгэхээр энэ чанаргүй зураг төсөл, гүйцэтгэлийн асуудлыг Барилга хот байгуулалтын яамны хэмжээнд ярихгүй бол өнөөдөр бид нар энд мянга хэлэлцээд ч шийдэгдэхгүй. Эцсийн бүлэгт улсын комисс гээд ажиллаж байгаа бид нар дээр л хариуцлагын асуудал яригдаж байна. Комиссын гишүүд гээд хэдэн хүмүүс цуглардаг тэгээд улсын комиссын акт дүгнэлт гээд гарын үсэг зурж баталгаажуулаад гардаг тэрийн үндэслээд цааш нь ашиглаад явдаг. Дараа нь ашиглалтын явцад олон хүндрэлтэй асуудлууд гардаг мөн аваар осол гараад хүний эрүүл мэндээр хохировол яах билээ гээд ярьвал их зүйл байна. Цаашид ялангуяа зураг төсөл зохиогч байгууллага энэ тал дээр маш сайн анхаарч ажиллах л хэрэгтэй байна.
Гүйцэтгэгч байгууллагуудаас саналаа хэлээрэй.

**"Цац орхон" ХХК-н захирал Ө.Баярхүү:**

Бидны хувьд 2018 оны төсвөөр хийгдсэн ажил. Энэ төсөв нь 2021 онд батлагдаад тэр төсвөөр хийгдсэн. Угсралтын ажил нь ковид дөнгөж өнгөрөөд хил нээгдэхэд эхэлсэн тухайн үед бараа материал тээврийн үнэ огцом өссөн байсан үе. Үндсэн материал болох бетон зуурмагыг орон нутгийн ганц үйлдвэрээс л авдаг байсан. Тухайн байгууллага нь "Борхойн өргөө" ХХК гэдэг байгууллага байсан тэдний хэлсэн үнээр нь авахгүй бол бетон нийлүүлэх боломжгүй гэдэг манай байгууллагын хувьд хамгийн өндөр чанрын бетон хэрэглэдэг байсан. Мөн арматур гэхэд тухайн үед 3,2 сая орчим гэх мэтчлэн байдгаа шавхаад л өнөөдрийн хэмжээнд дуусгаж одоо комисс ажиллаж байна. Төсөө өсгүүлье гэдэг хүсэлтийг захиалагч байгууллагад гаргахад засгын газрын 88-р тогтоол гарснаас 2 хоногийн дараа батлагдсан төсөв учир үнийн дүнгийн өсөлтөнд орох боломжгүй гэсэн. Цаг үеийн тун хүнд үед нэгэнтээ чадна гээд гэрээ хийгээд авсан ажил гээд чадлынхаа хэмжээнд л гүйцэтгэж дуусгалаа.
Удвалмядаг даргын хэлээд байгаа галын шланг гэдэг нь манай барилгад анхнаасаа цэвэр усны шугам орж ирээгүй шланг тавих боломжгүй хэрэв анхнаасаа цэвэр усны шугам сүлжээ ороод ирчихсэн байсан бол түүнийг тавихад асуудалгүй байсан. Мөн зохиогчийн дүгнэлт үүнтэй холбоотой гарсан байдаг.

**Г.Батзориг: "Гегатера тех" ХХК-н захирал**
Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын богино хугацаанд хийж гүйцэтгэж комисст хүлээлгэн өгөх саналтай байна.

**Ц.Баярмаа:** Нийт гишүүд үүрэг даалгавар, санал дүгнэлтээ хэлж дууссан тул комиссын хурлаа өндөрлөе.

**Шийдвэрлэсэн нь:** Комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврыг ажлын 14 хоногт багтаан бүрэн биелүүлж, үүрэг даалгаврын биелэлт гарсны дараа байнгын ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.

*Саналын хуудсыг хавсаргав.*

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН
КОМИССЫН ДАРГА: Ц.БАЯРМАА

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: Ц.БАТХҮҮ